



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 13/01

Чойбалсан хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 47 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Адуунчулуун” ХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хэлэлцээд нэгж хувьцаанд 50 /Тавь/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг компанийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-иар зуучлуулан гүйцэтгүүлж, ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор мөнгөн хэлбэрээр тараасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэлийг байгуулж, төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал /Ш.Баясгалан/-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА  
ГИШҮҮД:



*[Signature]* Б.ШАТАР  
*[Signature]* Ө.АМАРЖАРГАЛ  
*[Signature]* С.БАДАРЧ  
*[Signature]* Ю.БАТБААТАР  
*[Signature]* Б.БАТСАЙХАН  
*[Signature]* Ш.БАЯСГАЛАН  
*[Signature]* Н.БОЛДРАГЧАА  
*[Signature]* Ш.ИДЭР  
*[Signature]* Н.ЭНХЦЭЦЭГ